**НИЙСЛЭЛИЙН**
**СОНГИНОХАЙРХАН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН**
**ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 26 өдөр Дугаар A/06 Улаанбаатар хот

Төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөрийн жишиг үнэ батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 24 дүгээр зүйлийн 24.3, 24.4, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.4, 21 дүгээр зүйлийн 21.4, 21.5, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 02 дугаар сарын 28-ны дугаар 49/А/118 Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаал, Сонгинохайрхан нэгдсэн эмнэлгийн 2021 оны 09 дугаар сарын 09-ний өдрийн Удирдлагын Зөвлөлийн хурлын шийдвэр, Эмнэлгийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.7, 4 дүгээр зүйлийн 4.1.4 хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.6.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөрийн жишиг хэмжээ"-г хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөрийн жишиг хэмжээ, байгууллагад хэрэгжүүлэх төлыөртэй тусламжийн хэмжээг цахим хуудас, мэдээлэлийн самбарт ил тод байршуулан иргэдийг мэдээллээр ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, дэмжих төв эрхэлсэн дэд захирал (Б.Баяндалай)-д үүрэг болгосугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр ханган явцын хяналт хийж ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (Д.Сүнжидмаа)-д, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга (Д.Зулаа)-д даалгасугай.

4. Тушаалыг хэрэгжүүлж төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн тооцоог тухайн цаг хугацаанд нь хийлгэж ажиллахыг тасгийн эрхлэгч нар, санхүү хангамжийн албаны даргад, төлбөрт үйлчилгээний бүртгэл тооцоог удирдлагын багт улирал, хагас, бүтэн жилээр танилцуулж үр дүнг тооцож ажиллахыг Санхүү хангамжийн албаны дарга (Ж.Баярмагнай)-д тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын албаны дарга (Ш.Батбилэг)-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эмнэлгийн даргын 2022 оны 04 сарын 15-ны өдрийн А/27 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ Ц.ОЛОНБАЯР

9022091092 9091793 СБТ19971

3180710008

Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлгийн
захирлын 2023 оны 01 дүгээр сарын
20...дугаар А/06......дугаар тушаалын
хавсралт

## ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ЖИШИГ ХЭМЖЭЭ

| 1. Эрүүл мэндийн дүгнэлт гаргах | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Жолооны эрүүл мэндийн үзлэг | 1 хүн | 50 000 | 11101005 |
| 2 | Гэр бүл болох, ажил сургуульд орох эрүүл мэндийн үзлэг эрүүл мэндийн үзлэг | 1 хүн | 80 000 | 1110104 |
| 3 | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг / ЭМС-ын 611 тоот тушаалын / | 1 хүн | 20 000 | |
| 4 | Гадаадад явахад шаардлагатай эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ | 1 хүн | 80 000 | 11101003 |
| 5 | Буу галт зэвсэг эзэмших хүний урьдчилан сэргийлэх үзлэг | 1 хүн | 20 000 | 11101002 |
| 6 | Худалдаа үйлчилгээний байгууллагын эрүүл мэндийн үзлэг шинжилгээ | 1 хүн | 40 000 | |
| 7 | Аж ахуйн нэгж байгууллагын захиалгаар захион байгуулсан багцын урьдчилан сэргийлэх үзлэг,эрт илрүүлэг,оношлогоо,шинжилгээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээ | 1 хүн | Гэрээний үнийн дүнгээр | 11101001 |
| 8 | Унтуулгатай уян дуран(Бүдүүн гэдэс,уушиг,улаан хоолой,ходоод төвөнх) | 1 удаа | 100000 | 10202002 |
| 9 | Эрүүл мэндийн даатгалын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ | | Бодит өртгөөр | 19901001 |

## ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГТ АЖИЛЛУУЛАХ ТӨЛБӨРТЭЙ ОРНЫ ТОО,ХОНОГИЙН ТӨЛБӨР

| № | Тасаг нэгжийн нэр | Өрөөний дугаар | Орны тоо | Нэг хоногийн төлбөр | Сангийн сайд, ЭМС 49, А/118 | Код |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хүүхдийн тасаг / Нийт 12 ор / | /3-5/ | 2 | 20,000 | 10,000-30,000 / хагас люкс / | 31401005 |
| | | / 3-6 / | 2 | | | |
| | | / 3-12 / | 2 | | | |
| | | / 4-5 / | 2 | | | |
| | | / 4-6 / | 2 | | | |
| | | / 4-14 / | 2 | | | |
| 2 | Хүүхдийн Эрчимт Эмчилгээний тасаг / нийт 1 ор / | 3 | 1 | 20,000 | 10,000-30,000 / хагас люкс / | |
| 3 | Дотрын өвчин | / 4-5 / | 2 | | 10,000-30,000 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | судлалын тасаг / Нийт 10 ор / | / 4-6 / | 2 | 30,000 | / хагас люкс / | |
| | | / 4-7 / | 3 | | | |
| | | / 4-8 / | 3 | | | |
| 4 | Мэдрэлийн өвчин судлалын тасаг / Нийт 4 ор / | / 3-5 / | 2 | 30,000 | 10,000-30,000 / хагас люкс / | |
| | | / 3-6 / | 2 | | | |
| 5 | Мэс засал, Гэмтэл-н тасаг / Нийт 7 ор / | / 3-4 / | 2 | 30,000 | 10,000-30,000 / хагас люкс / | |
| | | / 3-5 / | 2 | | | |
| | | / 3-6 / | 3 | | | |

| **Нэмэлт төлбөрт үйлчилгээний жагсаалт,төлбөрийн хэмжээ** | | | |
|---|---|---|---|
| 1 | Дурангийн биопси | 1 | 40 000 |
| 2 | Эсийн шинжилгээ | 1 | 55 000 |
| 3 | Шарил хадаглах | 1 хоног | 28 000 |
| 4 | Өрхийн нас баралтын эмгэг судлалын шинжилгээ, дүгнэлт | 1 | 131 000 |
| 5 | Хувийн хэвшлийн нас баралтын эмгэг судлалын шинжилгээ,дүгнэлт | 1 | 702 000 |
| 6 | Ариутгал халдваргүйтгэл (автоклавын ) | 1 бикс | 15000 |
| 7 | Боолтын жижиг бэлдэц (15*15) | | 10000 |
| 8 | Плазмын | | 25000 |
| 9 | Эмгэг судлалын шинжилгээ хийж,онош тавьж дүгнэлт өгөх | 1 | 300000 |
| 10 | Амьд сорьцод оношлогооны эдийн шинжилгээ хийж, онош тавьж дүгнэлт өгөх (эд) | 1 | 40000 |
| 11 | Амьд сорьцод оношлогооны эдийн шинжилгээ хийж, онош тавьж дүгнэлт өгөх (эс) | 1 | 20000 |
| 12 | Мэс заслын дараах эдийн шинжилгээ хийж, онош тавьж дүгнэлт өгөх | 1 | 40000 |
| 13 | Холтер зүрхний цахилгаан бичлэг | 1 | 80000 |